



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ, 2025

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээний үзүүлэлтийг тус тус баталсан.

Нэг. Хяналт-шинжилгээ зорилго

Хяналт-шинжилгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, төсөл, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, бодлогын хэрэгжилт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Үндэслэл, арга зүй

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.”, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, Засгийн газарт танилцуулах” гэж заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг баримтлан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийв.

“Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 5.2-т заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад байгууллагаас Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд ирүүлсэн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцын тайлан, мэдээллийг хянан үзэж, төлөвлөгөөнд тусгагдсан 4 бодлогын хүрээнд хамаарах 328 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн ахиц, өөрчлөлтөөр дээрх журмын 6.1-д заасан аргачлалаар, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцын үр дүнг 6.5-д заасан аргачлалаар тус тус тооцож дүгнэв.

Гурав. Хяналт-шинжилгээний дүн

3.1. Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг үндсэн 4 бодлогын хүрээнд 20 чиглэл, 391 дэд чиглэлтэйгээр баталсан.

Хүснэгт 1. Тэргүүлэх чиглэлийн төлөвлөлт

Бодлого	Чиглэл	Дэд чиглэл
Нэг. Эдийн засгийн бодлого	1.1. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалж, өгөөжийг өрх бүрд хүргэнэ.	4
	1.2. Эдийн засгийн тэргүүлэх салбарт реформыг хэрэгжүүлнэ. 6 дэд чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 62 үйл ажиллагаа	62
	1.3. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна.	27

	1.4.Ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангана.	25
	1.5.Шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурласан мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлнэ.	17
Хоёр.Бүсчилсэн хөгжлийн бодлого	2.1.Байгалийн баялаг, нөөц, байршлын давуу талд тулгуурласан бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлнэ.	45
	2.2."20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан "Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040" болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	42
Гурав.Хүний хөгжлийн бодлого	3.1.Үндэсний орон сууцжуулах бодлогыг Үндэсний баялгийн сантай уялдуулан хэрэгжүүлнэ.	15
	3.2.Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөхүйц чадвартай төгсөгчдийг бэлтгэнэ.	29
	3.3.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг эрчимжүүлнэ.	17
	3.4.Нийгмийн баталгааг сайжруулж, хүн амын бүлгийн онцлогт нийцсэн бодлогыг хэрэгжүүлнэ.	35
	3.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хүн амын бүлэгт зориулан оновчтой хэрэгжүүлнэ.	15
	3.6.Соёл, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4
Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	4.1.Төрийн шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглаж, иргэдэд ойр төрийн үйлчилгээг бий болгоно /Ухаалаг "E-Mongolia", AI шинэчлэл-Цахим засаглал/.	7
	4.2.Хүний эрхийн баталгааг хангана.	8
	4.3.Хараат бус, ил тод шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ.	8
	4.4.Авлигатай тэмцэх ажиллагааг үргэлжлүүлнэ.	7
	4.5.Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааг хангана.	2
	4.6.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ.	10
	4.7.Орчны аюулгүй байдлыг хангаж, хүн, нийгмийн амар тайван орчныг бий болгоно.	12
	20	391

3.2.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд 4 бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 28 үр дүн, хөтөлбөрийн 63 үр дүн, 328 төсөл, арга хэмжээ, гүйцэтгэлийн 375 шалгуур үзүүлэлт тусгагдсан. ба төлөвлөгөөний биелэлт дунджаар 26.8 хувь байна.

Хүснэгт 2.Төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг

Бодлого	ТЭЗ үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	ТАХ шалгуур үзүүлэлт
Нэг.Эдийн засгийн бодлого	12	30	167	191
Хоёр.Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	6	53	58
Гурав.Хүний хөгжлийн бодлого	7	15	58	72
Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	6	12	50	54
ДҮН	28	63	328	375

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 28 үр дүнгийн хэрэгжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дунджаар авч үзэхэд, Эдийн засгийн бодлогын хүрээнд тодорхойлсон 12 үр дүнгийн хэрэгжилт дунджаар 20.0 хувь, Бүсчилсэн хөгжлийн бодлогын 3 үр дүнгийн хэрэгжилт дунджаар 23.4 хувь, Хүний хөгжлийн бодлогын 7 үр дүнгийн хэрэгжилт 47.7 хувь, Хүнийг эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын 6 үр дүнгийн хэрэгжилт 40.9 хувь байна.

Дээрх ТЭЗ-ийн үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн хөтөлбөрийн 63 үр дүнгийн хэрэгжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дунджаар авч үзэхэд, Эдийн засгийн бодлогод хамаарах 30 үр дүнгийн хэрэгжилт дунджаар 19.4 хувь, Бүсчилсэн хөгжлийн бодлогод хамаарах хөтөлбөрийн 6 үр дүнгийн хэрэгжилт дунджаар 21.7 хувь, Хүний хөгжлийн бодлогод хамаарах хөтөлбөрийн 15 үр дүнгийн хэрэгжилт 48.1 хувь, Хүнийг эрхийг дээдэлсэн засаглалын бодлогод хамаарах хөтөлбөрийн 12 үр дүнгийн хэрэгжилт 41.1 хувь байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 328 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар **26.8** хувь байна. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 328 төсөл, арга хэмжээний 13.7 хувь буюу 45 арга хэмжээ “үр дүнтэй”, 7.0 хувь буюу 23 арга хэмжээ “үр дүн хүлээгдэж байгаа”, 14.9 хувь буюу 49 арга хэмжээ “үр дүн хангалтгүй”, 64.3 хувь буюу 211 арга хэмжээ “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн байна.

Хүснэгт 3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт (бодлогоор, үр дүнгийн үнэлгээгээр)

Бодлого	ТЭЗ үр дүн	Хөтөлбөр үр дүн	Төсөл, арга хэмжээ	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт			
				Үр дүнтэй	Үр дүн хүлээгдэж байгаа	Үр дүн хангалтгүй	Үр дүн гараагүй
Нэг.Эдийн засгийн бодлого	12	30	167	19	8	16	124
Хоёр.Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	6	53	2	4	14	33
Гурав.Хүний хөгжлийн бодлого	7	15	58	19	5	6	28
Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	6	12	50	5	6	13	26
Нийт дүн	28	63	328	45	23	49	211

Нийт төсөл, арга хэмжээний 64.3 хувь нь 30.0 хувиас бага буюу “үр дүн гараагүй” гэж үнэлэгдсэн ба эдгээр төсөл арга хэмжээ хэрэгжээгүй нь шаардлагатай төсөв, санхүүжилт батлагдаагүй, хэрэгжүүлэх төслийн урьдчилсан, бэлтгэл шатны ажлууд удаашралтай байгаа, мөн хэрэгжилтийг бүрэн, тодорхой тайлагнаагүй буюу шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй, өмнөх оны гүйцэтгэлийг тайлагнасан, энэ онд ахиц гараагүй зэрэгтэй холбоотой байна. Тухайлбал,

- Санхүүжилт тодорхойгүй, улсын төсөвт санал хүргүүлсэн ч батлагдаагүй, төсөвт тусгаагүй “Өмнөговь аймгийн Гурвантэс суманд “Нийтийн зориулалтын тээвэр логистик, агуулахын терминал” барих”, “Налайх-Тэрэлж чиглэлийн 37 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх” зэрэг 15 төсөл арга хэмжээ;
- 2025 онд тодорхой ажил хийгдээгүй, хийсэн ажлаа тайлагнаагүй буюу өмнөх оны гүйцэтгэлийг тайлагнасан “1.12.2.1. Шинжлэх ухаан, технологи болон аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн үндэсний технологи дамжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх”, “2.3.1.19. Агаар, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”, “1.4.1. Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлнэ” зэрэг 17 арга хэмжээ;
- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилсан шатны бэлтгэл ажлууд буюу судалгаа шинжилгээ хийх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хянах, тендер шалгаруулалт, гэрээ хэлцэл хийх зэрэг ажил удааширалтай явагдаж буй “1.8.2.2. “Мөрөн” нисэх буудлыг 4С ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх”, “2.3.2.3. Шинэ Зуунмод хотын эхний

ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээний бүтээн байгуулалтыг эхлүүлэх” зэрэг 73 төсөл, арга хэмжээ;

- Төсөл арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй “1.1.2.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд үе шаттай нээлттэй худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх”, “1.4.3.7. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах” зэрэг 43 төсөл арга хэмжээ;

- Шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг тогтоогоогүй “2.3.1.24. Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор орон сууцны дулаалгын ажлыг оршин суугчдын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийх” зэрэг төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 4.Төлөвлөсөн үр дүн болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт

№	Бодлого	ТЕЗ үр дүн		Хөтөлбөрийн үр дүн		Төсөл, арга хэмжээ	
		тоо	Хэрэгжилт (хувь)	тоо	Хэрэгжилт (хувь)	тоо	Хэрэгжилт (хувь)
1	Нэг. Эдийн засгийн бодлого	12	20.0	30	19.4	167	21.4
2	Хоёр. Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	23.4	6	21.6	53	23.1
3	Гурав. Хүний хөгжлийн бодлого	7	47.7	15	48.0	58	43.4
4	Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	6	40.9	12	41.1	50	29.5

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийг төсөл, арга хэмжээний дунджаар авч үзэхэд, ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилт дунджаар 33.0, хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилт 32.5 хувь байна.

3.2.1.Эдийн засгийн бодлогын хэрэгжилт

Эдийн засгийн бодлогын хүрээнд ТЕЗ-ийн 12 үр дүн, хөтөлбөрийн 30 үр дүн, 167 төсөл, арга хэмжээ тусгагдсан ба бодлогын хэрэгжилт дунджаар 21.4 хувь байна.

Дээрх бодлогын хүрээнд төлөвлөсөн ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж эхний хагас жилийн байдлаар 20.0 хувь байгаа бөгөөд нийт 12 үр дүнгийн хэрэгжилт 50.0 хувьд хүрээгүй буюу 2 үр дүн “үр дүн хангалтгүй” 10 үр дүн “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн. “Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.” үр дүнгийн хэрэгжилт 46.3 хувь, “Дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлнэ.” үр дүнгийн хэрэгжилт 31.6 хувь байгаа нь бусад үр дүнгээс илүү үзүүлэлт байна.

Зураг 1. Эдийн засгийн бодлогын ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж хувь



Дээрх бодлогын ТЕЗ-ийн 12 үр дүнд хамаарах 30 хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж 19.4 хувь байна.

Хүснэгт 5.Хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилт

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Хэрэгжил- тийн дундаж
1.1. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	1.1.1. Гадаад худалдаа, экспорт хийх таатай орчныг бүрдүүлнэ.	20.83
	1.1.2. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна.	9.09
	1.1.3. Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг хөгжүүлнэ.	20.00
1.2. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	1.2.1. Малын ашиг шимийг нэмэгдүүлж, малыг чанаржуулна.	6.13
	1.2.2. Олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг малын халдварт өвчнийг бууруулна.	0.00
	1.2.3. Үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг бий болгож, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	0.00
1.3. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоод хангамжийг нэмэгдүүлнэ.	1.3.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	12.55
1.4. Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	1.4.1. Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлнэ.	0.00
	1.4.2. Ордуудын ашиглалтыг нэмэгдүүлнэ.	100.00
	1.4.3. Боловсруулах хүнд үйлдвэрийг нэмэгдүүлнэ.	14.95
1.5. Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1.5.1. Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	33.13
	1.5.2. Авто замын сүлжээг өргөтгөнө.	27.09
1.6. Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1.6.1. Олон улсын жишигт нийцсэн боомтын тоог нэмэгдүүлнэ.	27.96
1.7. Эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангана.	1.7.1. Эрчим хүчний салбарыг эдийн засгийн үр ашигтай болгоно.	18.08
	1.7.2. Сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.	34.44
	1.7.3. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	16.83
1.8. Дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлнэ.	1.8.1. Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	19.63
	1.8.2. Агаарын тээврээр зорчих жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	16.67
	1.8.3. Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	38.51
1.9. Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	1.9.1. Банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ.	46.25
1.10. Байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	1.10.1. Байгаль орчинд ээлтэй, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	0.00
	1.10.2. Ногоон эдийн засгийн санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ.	15.00
1.11. Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	1.11.1. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	0.00
	1.11.2. Ашиглалтад өртөмтгий ургамлын ашиглалтын нөөцийг тогтоож, амьтны ашиглалтын нөөцийг нэмэгдүүлнэ.	8.32
	1.11.3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн усны нөөц, хуримтлалыг нэмэгдүүлнэ.	22.00
	1.11.4. Цөлжилт, газрын доройтлыг бууруулна.	0.00

1.12. Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлнэ.	1.12.1. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ.	0.00
	1.12.2. Хувийн хэвшлийн шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дэмжиж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.	23.33
	1.12.3. Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг хөгжүүлнэ.	35.00
	1.12.4. Шинжлэх ухааны паркийг байгуулна.	16.67

Хөтөлбөрийн үр дүнгээс харахад “1.4.2. Ордуудын ашиглалтыг нэмэгдүүлнэ” үр дүн 100 хувь буюу “үр дүнтэй” үнэлэгдсэн байна. Тус хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн “1.4.2.1. “Монгол, Францын хамтарсан “Ураны төсөл” төслийн бэлтгэл ажлыг эхлүүлэх” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц улсын Орано майнинг группийн хооронд “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд гарын үсэг зурах эрх олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр талууд гарын үсэг зурсан. Мөн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.

Эдийн засгийн бодлогын хүрээнд ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 167 төсөл, арга хэмжээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар, дунджаар 21.4 хувь байна.

Хүснэгт 6. Эдийн засгийн бодлогын хүрээний төсөл, арга хэмжээний хэрэгжилт

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт			
			Үр дүнтэй	Үр дүн хүлээгдэж байгаа	Үр дүн хангалтгүй	Үр дүн гараагүй
1.1. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	3	6	-	-	1	5
1.2. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	3	13	-	-	-	13
1.3. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоод хангамжийг нэмэгдүүлнэ.	1	5	-	-	1	4
1.4. Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	3	18	1	2	1	14
1.5. Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	2	27	5	1	4	17
1.6. Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1	8	1	-	2	5
1.7. Эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангана.	3	27	3	2	1	21
1.8. Дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлнэ.	3	30	6	1	4	19
1.9. Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	1	4	2	-	-	2
1.10. Байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	2	3	-	-	1	2
1.11. Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	4	13	1	-	-	12
1.12. Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлнэ.	4	13	-	2	1	10
Нийт дүн	30	167	19	8	16	124

Эдийн засгийн бодлогын хүрээнд төлөвлөсөн 167 төсөл, арга хэмжээний 11.4 хувь нь “үр дүнтэй”, 4.8 хувь “үр дүн хүлээгдэж байгаа”, 5.6 хувь “үр дүн хангалтгүй”, 74.3 хувь “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн байна.

3.2.2.Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд ТЕЗ-ийн 3 үр дүн, хөтөлбөрийн 6 үр дүн, 53 төсөл, арга хэмжээ тусгагдсан ба бодлогын хэрэгжилт дунджаар 23.1 хувь байна.

ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж эхний хагас жилийн байдлаар 23.4 хувь байгаа бөгөөд нийт 3 үр дүнгийн хэрэгжилт 30 хувьд хүрээгүй буюу “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн.

Зураг 2.Бүсчилсэн хөгжлийн бодлогын ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж хувь



ТЕЗ-ийн үр дүнд хамаарах хөтөлбөрийн 6 үр дүнгийн хэрэгжилтийн дундаж 21.65 хувь байна. “Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” хөтөлбөрийн үр дүн 40.45 хувь байгаа нь бусад үр дүнгээс илүү үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээний хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилт

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Хэрэгжилтийн дундаж
2.1. Орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлнэ.	2.1.1. Орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.	13.94
	2.1.2. Бүс, орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	23.37
2.2. Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	2.2.1. Авто замын ачааллыг бууруулна.	10.00
	2.2.2. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	40.45
2.3. Төвлөрлийг сааруулж, агаарын бохирдлыг бууруулна.	2.3.1. Инженерийн бүрэн хангамжтай сууцанд амьдардаг өрхийн тоог нэмэгдүүлнэ.	27.13
	2.3.2. Шинэ суурьшлын бүсэд инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	15.00

Бүсчилсэн хөгжлийн бодлогын ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 53 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 23.1 хувь байна.

Хүснэгт 8.Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээний төсөл, арга хэмжээний хэрэгжилт

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн үр дүн			
			Үр дүнтэй	Үр дүн хүлээг-дэж байгаа	Үр дүн хангалтгүй	Үр дүн гараагүй
2.1. Орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлнэ.	2	16	1	1	2	12
2.2. Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	2	7	-	1	2	4
2.3. Төвлөрлийг сааруулж, агаарын бохирдлыг бууруулна.	2	30	1	2	10	17
Нийт дүн	6	53	2	4	14	33

Дээрх бодлогын хүрээнд төлөвлөсөн 53 төсөл, арга хэмжээний 3.8 хувь нь “үр дүнтэй”, 7.5 хувь “үр дүн хүлээгдэж байгаа”, 26.4 хувь “үр дүн хангалтгүй”, 62.3 хувь “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн байна.

3.2.3. Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилт

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд ТЕЗ-ийн 7 үр дүн, хөтөлбөрийн 15 үр дүн, 58 төсөл, арга хэмжээ тусгагдсан ба бодлогын хэрэгжилт дунджаар 43.4 хувь байна.

ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж эхний хагас жилийн байдлаар 47.7 хувь байгаа бөгөөд 1 үр дүн “Үр дүн гарсан”, 1 үр дүн “Үр дүн хүлээгдэж байгаа”, 4 үр дүн “үр дүн хангалтгүй”, 1 үр дүн “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн. “Нийгмийн баталгааг сайжруулна.” үр дүнгийн хэрэгжилт 100.0 хувь, “Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.” үр дүнгийн хэрэгжилт 62.5 хувь байгаа нь бусад үр дүнгээс илүү үзүүлэлт байна.

Зураг 3. Хүний хөгжлийн бодлогын ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж хувь



Дээрх бодлогын ТЕЗ-ийн 7 үр дүнд хамаарах 15 хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж 48.05 хувь байна.

Хүснэгт 9. Хүний хөгжлийн бодлогын хүрээний хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилт

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Хэрэгжилтийн дундаж
3.1. Өвчлөл, нас баралтыг бууруулна.	3.1.1. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлнэ.	30.00
	3.1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	52.52
	3.1.3. Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.	20.00
	3.1.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг боловсронгуй болгоно.	100.00
	3.1.5. Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлж, иргэдэд учрах чирэгдлийг бууруулна.	50.00
3.2. Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна	3.2.1. Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулийн орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ.	38.30
	3.2.2. Дээд боловсролын чанарын үзүүлэлтийг олон улсын түвшинд хүргэнэ.	25.00
	3.2.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын чанар, нийцлийг сайжруулна.	33.33
3.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	3.3.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.	16.67
	3.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь эрхийг хангана.	21.67
3.4. Нийгмийн баталгааг сайжруулна.	3.4.1. Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	100.00

	3.4.2. Төрийн албаны хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.	100.00
3.5.Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	3.5.1. Ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлнэ.	37.38
3.6.Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3.6.1. Иргэдийн соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	62.50
3.7.Түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	3.7.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлаж, хадгалалт, хамгаалалтын байдлыг сайжруулна.	33.33

Хүний хөгжлийн бодлогын ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 58 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 43.4 хувь байна.

Хүснэгт 10.Хүний хөгжлийн бодлогын хүрээний төсөл, хэрэгжилтийн үр дүнгийн тоо

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн үр дүн			
			Үр дүнтэй	Үр дүн хүлээгдэж байгаа	Үр дүн хангалтгүй	Үр дүн гараагүй
3.1. Өвчлөл, нас баралтыг бууруулна.	5	21	7	3	3	8
3.2.Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.	3	17	5	1	-	11
3.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	2	5	-	-	2	3
3.4. Нийгмийн баталгааг сайжруулна.	2	3	3	-	-	-
3.5. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	1	5	1	1	-	3
3.6.Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	4	2	-	1	1
3.7. Түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	1	3	1	-	-	2
Нийт	15	58	19	5	6	28

Дээрх бодлогын хүрээнд төлөвлөсөн 58 төсөл, арга хэмжээний 32.8 хувь нь “үр дүнтэй”, 8.6 хувь “үр дүн хүлээгдэж байгаа”, 10.3 хувь “үр дүн хангалтгүй”, 48.3 хувь “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн байна.

3.2.4.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хэрэгжилт

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд ТЕЗ-ийн 6 үр дүн, хөтөлбөрийн 12 үр дүн, 50 төсөл, арга хэмжээ тусгагдсан ба бодлогын хэрэгжилт дунджаар 29.5 хувь байна.

ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж эхний хагас жилийн байдлаар 40.9 хувь байгаа бөгөөд 1 үр дүн "үр дүн хүлээгдэж байгаа", 4 үр дүн “үр дүн хангалтгүй” 1 үр дүн “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн. “Хилийн аюулгүй байдлыг хангана.” үр дүнгийн хэрэгжилт 76.8 хувь, “Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.” үр дүнгийн хэрэгжилт 58.8 хувь байгаа нь бусад үр дүнгээс илүү үзүүлэлт байна.

Зураг 4.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын ТЕЗ-ийн үр дүнгийн хэрэгжилт



Дээрх бодлогын ТЕЗ-ийн 6 үр дүнд хамаарах 12 хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийн дундаж 41.07 хувь байна.

Хүснэгт 11. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын хүрээний хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилт

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Хэрэгжилтийн дундаж
4.1. Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	4.1.1. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна.	64.10
	4.1.2. Мэдээлэл, харилцаа холбооны хатуу, зөөлөн дэд бүтцийг өргөтгөж, сайжруулна.	2.78
4.2. Шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.	4.2.1. Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ.	37.50
	4.2.2. Шүүх шинжилгээний байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.	33.30
4.3. Авлигын гэмт хэргийг бууруулна.	4.3.1. Авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	0.00
	4.3.2. Авлигаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.	70.00
4.4. Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	4.4.1. Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлнэ.	58.75
4.5. Хилийн аюулгүй байдлыг хангана.	4.5.1. Хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ.	76.80
4.6. Орчны аюулгүй байдлыг хангана.	4.6.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг нэмэгдүүлнэ.	24.53
	4.6.2. Орчны чанарыг стандарт түвшинд хүргэнэ.	29.41
	4.6.3. Хүн, нийгмийн амар тайван байдлыг хангана.	68.38
	4.6.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ.	27.27

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 50 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 29.5 хувь байна.

Хүснэгт 12. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн үр дүн			
			Үр дүнтэй	Үр дүн хүлээгдэж байгаа	Үр дүн хангалтгүй	Үр дүн гараагүй
4.1. Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	2	15	-	1	1	13
4.2. Шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.	2	3	-	1	1	1
4.3. Авлигын гэмт хэргийг бууруулна.	2	2	-	1	-	1
4.4. Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	1	4	1	2	1	-
4.5. Хилийн аюулгүй байдлыг хангана.	1	3	2	-	1	-
4.6. Орчны аюулгүй байдлыг хангана.	4	23	2	1	9	11
Нийт дүн	12	50	5	6	13	26

Дээрх бодлогын хүрээнд төлөвлөсөн 50 төсөл, арга хэмжээний 10.0 хувь нь “үр дүнтэй”, 12.0 хувь “үр дүн хүлээгдэж байгаа”, 26.0 хувь “үр дүн хангалтгүй”, 52.0 хувь “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн байна.

3.3. Санхүүжилтийн гүйцэтгэл

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд нийт 328 төсөл, арга хэмжээг 19,359.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 1599.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн нь нийт төлөвлөсөн дүнгийн 8.3 хувийг эзэлж байна.

Нийт 328 төсөл, арга хэмжээнээс санхүүжүүлэх эх үүсвэр тусгаагүй 2, мөнгөн дүнг төлөвлөгөөнд тусгаагүй 39 төсөл, арга хэмжээний 51 шалгуур үзүүлэлт байна.

Хүснэгт 11.Төсөл, арга хэмжээний санхүүжилт, эх үүсвэр

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөсөн		Гүйцэтгэл	
		Төсөл, арга хэмжээ	Төлөвлөсөн (тэрбум.төг)	Төсөл, арга хэмжээ	Зарцуулсан (тэрбум.төг)
1.	Улсын төсөв	176	4,630.9	65	166.7
2.	Улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	1	60.0	0	-
3.	Улсын төсөв, орон нутгийн төсөв	2	119.5	1	22.0
4.	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	-	-	4	10.1
5.	Орон нутгийн төсөв	7	246.3	2	13.8
6.	Гадаад зээл	64	2,127.3	1	0.2
7.	Гадаад тусламж	12	361.4	0	-
8.	Гадаад зээл /Үнэт цаас/	3	1,582.5	0	-
9.	Гадаадын зээл тусламж	4	80.4	37	1,324.3
10.	Орон нутгийн төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	1	220.0	1	-
11.	Орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр	1	-	0	-
12.	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	16	2,913.3	6	27.5
13.	Төр, хувийн хэвшлийн түншлэл	28	3,477.9	5	35.0
14.	Төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	4	985.7	0	-
15.	Дотоодын хөрөнгө оруулалт	1	804.8	0	-
16.	Шууд хөрөнгө оруулалт	2	449.0	2	-
17.	Бусад эх үүсвэр	4	1,300.2	0	-
18.	Эх үүсвэр заагаагүй	2	-	0	-
Нийт дүн		328	19,359.1	124	1,599.6

Дээрх санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллийг бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэсэн бөгөөд Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам нь санхүүжилтийн гүйцэтгэлийн бодит мэдээллийг ирүүлээгүй буюу төлөвлөсөн санхүүжилтийг гүйцэтгэлээр тайлагнасан, алдааг залруулж мэдээллийг дахин ирүүлээгүй тул гүйцэтгэлийн тоон мэдээллийг хасч тооцсон болно.

3.4.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээний үзүүлэлт

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг баталсан. Тус хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд тэргүүлэх чиглэлийн 6, ТЕЗ-ийн 47, хөтөлбөрийн 91, нийт 144 үзүүлэлт тусгагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтийн мэдээллийн эх сурвалж болох 46 байгууллага, мөн мэдээллийг хариуцах төрийн 27 байгууллагыг тус тус заасан байна.

Хүснэгт 12.Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Бодлого	ХШҮ шалгуур үзүүлэлт		
		Тэргүүлэх чиглэл	ТЕЗ үр дүн	Хөтөлбөрийн үр дүн
1	Нэг. Эдийн засгийн бодлого	1	16	43

2	Хоёр. Бүсчилсэн хөгжлийн бодлого	2	3	6
3	Гурав. Хүний хөгжлийн бодлого	1	22	18
4	Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	2	6	24
	ДҮН	6	47	91

Дээрх нийт 144 үзүүлэлтээс 127 үзүүлэлтийн мэдээллийг цуглуулах давтамж жилд 1 удаа байгаа бол 2 мэдээллийг улирал тутам, 2 мэдээллийг хагас, бүтэн жилээр, 3 мэдээллийг 2 жил тутам, 5 мэдээллийг 3 жил тутам, 2 мэдээллийг 4 жил тутам, 2 мэдээллийг 5 жил тутам цуглуулахаар заасан, мөн 1 мэдээллийг шинээр тооцож гаргахаар тус тус баталсан.

Банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилтот үр дүнгийн хүрээнд Монгол банкнаас улирал тутам гаргах “Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа” шалгуур үзүүлэлтийн улирлын мэдээллийг холбогдох байгууллагаас тайлагнаагүй байна.

“Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.” зорилтот үр дүнгийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргах “Хүүхэд хамгаалал шаардлагатай /зорилтот/ нийт хүүхдээс хувийн хэрэг нээсэн хүүхдийн эзлэх хувь” үзүүлэлтийн мэдээллийг улирал тутам, “Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн эзлэх хувь” үзүүлэлтийг хагас, бүтэн жилээр, мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь эрхийг хангана.” зорилтот үр дүнгийн хүрээнд тодорхойлсон “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүдээр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь” үзүүлэлтийг хагас, бүтэн жилээр гаргахаар заасан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн дээрх 3 үзүүлэлтийн хагас жилийн мэдээллийг харахад,

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүдээр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь” үзүүлэлт эхний хагас жилийн байдлаар зорилтот түвшний 80.3 хувийг хангасан байгаа ч энэ нь улсын хэмжээний нийт дүнгээр тооцогдоогүй байна.

- Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн эзлэх хувь эхний хагас жилийн байдлаар 11.0 хувь байгаа нь суурь түвшнээс ч бага үзүүлэлт байна.

- “Хүүхэд хамгаалал шаардлагатай /зорилтот/ нийт хүүхдээс хувийн хэрэг нээсэн хүүхдийн эзлэх хувь” үзүүлэлтийг тооцож тайлагнаагүй, өөр үзүүлэлт тайлагнасан байна.

“Орчны аюулгүй байдлыг хангах” зорилгын үр дүнг “Орчны эрсдэлийн түвшин” гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн ба энэ үзүүлэлтийг шинээр тооцохтой холбоотойгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас аргачлалыг боловсруулж батлуулах чиглэлээр тодорхой ажил хийгээгүй байна.

Дээрх 4 үзүүлэлтээс бусад шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг бүтэн жилийн дүнгээр тооцох тул эхний хагас жилийн байдлаар тооцох боломжгүй байна.


3.5.Хэрэгжүүлэгч байгууллага

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг нийт 28 байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр, үүнээс 3 арга хэмжээг тус бүр 2 байгууллага хамтран хэрэгжүүлэхээр тусгасан.

Төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга, хэмжээний хэрэгжилтийн байдлыг хэрэгжүүлэгч байгууллагаар авч үзвэл, Батлан хамгаалах яам, Хууль зүй, дотоод

хэргийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Шүүхийн Ерөнхий зөвлөл 50.0 ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 5. Яамны хариуцсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт (үр дүнгийн үнэлгээ болон арга хэмжээний тоогоор)



Хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг авч үзвэл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хамтран хэрэгжүүлэх 1 арга хэмжээ, Боловсролын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны хамтран хэрэгжүүлэх 1 арга хэмжээ үр дүнгүй буюу хэрэгжээгүй байна.

Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн буюу төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо", "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих" цахим системүүдийн интеграци хийх холболтын ажлыг 2025 оны 06 дугаар сард хийж дууссан байна. Ингэснээр бодит цагийн горимоор төрийн албатай холбоотой холбогдох мэдээлэл болон 207000 төрийн албаны хаагчийн хувийн хэрэг болон цалин хөлс, шилжилт хөдөлгөөн, сонгон шалгаруулалтын мэдээллийг Засгийн газрын бодлого шийдвэрт ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд 4 бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 28 үр дүн, хөтөлбөрийн 63 үр дүн, 328 төсөл, арга хэмжээ, гүйцэтгэлийн 375 шалгуур үзүүлэлт тусгагдсан ба төлөвлөгөөний биелэлт дунджаар 26.8 хувь байна. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 328 төсөл, арга хэмжээний 13.7 хувь буюу 45 арга хэмжээ "үр дүнтэй", 7.0 хувь буюу 23 арга хэмжээ "үр дүн хүлээгдэж байгаа", 14.9 хувь буюу 49 арга хэмжээ "үр дүн хангалтгүй", 64.3 хувь буюу 211 арга хэмжээ "үр дүн гараагүй" гэж дүгнэгдсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 328 төсөл, арга хэмжээний 64.3 хувь нь үр дүн гараагүй гэж үнэлэгдсэн байгаа нь шаардлагатай төсөв, санхүүжилт батлагдаагүй, хэрэгжүүлэх төслийн урьдчилсан, бэлтгэл шатны

ажлууд удаашралтай байгаа, мөн хэрэгжилтийг бүрэн, тодорхой тайлагнаагүй буюу шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй, өмнөх оны гүйцэтгэлийг тайлагнасан, энэ онд ахиц гараагүй зэрэгтэй холбоотой байна.

Хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа арга хэмжээний урьдчилсан судалгааг бүрэн хийж, нөхцөл байдал, хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний хүрээг зөв тодорхойлоогүй, он дамжин хэрэгжих болон тухайн онд шинээр хэрэгжих арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг үйл ажиллагааны эрэмбэ дараалал, үе шатнаас хамааруулан оновчтой төлөвлөөгүй, мөн төлөвлөгөөний төслийг дээд шатны байгууллагад өргөн барихаас өмнө бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудад танилцуулж эцэслэн тохироогүйгээс төлөвлөгөөнд хэрэгжих боломжгүй арга хэмжээ нэмж тусгагдсан зэргээс шалтгаалан зарим төсөл, арга хэмжээний биелэлт хангагдахгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13, 6.10.1-д зааснаар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг болох тул эдгээр 2 бодлогын баримт бичгийн уялдаа холбоог авч үзэхэд, үндсэн чиглэлд тусгагдсан нийт төлөвлөсөн хүрэх үр дүнгийн 46.3 хувийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг үндсэн 4 бодлогын хүрээнд 20 чиглэл, 391 дэд чиглэлтэйгээр баталсан нь хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээтэй шууд болон агуулгын хувьд давхардсан шинжтэй байгаа нь тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний давхардлыг бий болгож байна. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө нь Монгол Улсын 2025 онд баримтлах тэргүүлэх чиглэлийг хангахад чиглэх бөгөөд тэргүүлэх чиглэлийг бодлогын салбар, чиглэл бүрээр нарийвчлан 391 заалтаар, төсөл, арга хэмжээтэй зэрэгцүүлж тодорхойлж баталсан нь тэргүүлэх чиглэл гэсэн үндсэн логикийг алдагдуулсан байна.

Цаашид Монгол Улсын тухайн жилд баримтлах тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт хоорондын уялдаа холбоо, хамаарал, нөлөөллийг тооцож, нийцлийг ханган, бодлогын баримт бичгийг боловсруулж баталж байх шаардлагатай байна.

Тав. Санал

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт шинжилгээний дүнг үндэслэн цаашид дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Эдийн засаг, хөгжлийн яам:

1.1. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний бодлого, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нөхцөл байдлын дүн шинжилгээ, тухайн үйл ажиллагааны эрэмбэ дараалал, гүйцэтгэх үе шатанд тулгуурлан оновчтой тодорхойлж, төлөвлөх;

1.2. Тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн нийцлийг хангах;

1.3.Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх;

Хоёр. Сангийн яам:

2.1.Зураг төсөл, магадлал хийгдсэн барилга, байгууламж барих арга хэмжээг улсын төсөвт тусгадаггүйн улмаас магадлалын хүчинтэй хугацаа дуусч, мөн дахин магадлуулах шаардлага үүсэж төсвийн үр ашиггүй зарцуулалт гарч байгааг зогсоох арга хэмжээ авах;

2.2.Хөгжлийн бодлогын баримт бичгийн арга хэмжээ бүрээр төлөвлөсөн төсөв, санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллийг улирал тутамд нэгтгэн бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудад хүргүүлдэг байх арга хэмжээг зохион байгуулах;

Гурав. Төсвийн ерөнхийлөн захирагч нар:

3.1. “Үр дүн хангалтгүй” болон “үр дүн гараагүй” гэж дүгнэгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжээгүй шалтгааныг дэлгэрэнгүй тайлагнаж, хэрэгжилтийг эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах, бодлогын уялдааг сайжруулах, шаардлагатай бол төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

3.2.Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилсан шатны бэлтгэл ажлууд буюу судалгаа шинжилгээ хийх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хянах, тендер шалгаруулалт, гэрээ хэлцэл хийх зэрэг ажлыг шуурхай зохион байгуулах, энэ чиглэлээрх мэргэжлийн байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааны процессыг сайжруулах;

3.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээлэлтэй зөрүүгүй байдлаар тайлагнаж, олон нийтэд нээлттэй мэдээлдэг байх;

3.4.Үндэсний статистикийн хорооноос гаргадаггүй, салбарын статистик мэдээллийг тооцох аргачлалыг батлуулж, батлагдсан аргачлалын дагуу хүрсэн түвшинг тооцдог байх;

3.5.Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд, батлагдсан загварын дагуу нэгдсэн системд нотлох баримтын хамт бүрэн гүйцэд тайлагнаж байх;

3.6.Тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулж буй зардлыг бодитой тайлагнах нөхцөлийг бүрдүүлж, төсвийн шууд захирагчийн хөрөнгө зарцуулах, зардал гаргах тухай шийдвэрт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн холбогдох заалтыг үндэслэл хэсэгт тусгадаг байх зэрэг болно.

----- оОо -----